


Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны сонгууль

**Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
сонгуульд бие даан нэр дэвшигч Агваан овогтой  
Энхбаярын мөрийн хөтөлбөр**

Хөвсгөл аймаг, Мөрөн сум

2020 он



1000001

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД 37 ДУГААР ТОЙРОГТ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ АГВААН ОВОГТОЙ  
ЭНХБАЯРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ: БАГИЙН ИРГЭДИЙН НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЧИГЛЭЛЭЭР.

- 1.1 Хөвсгөл аймаг нь улсын хэмжээнд хамгийн өндөр үнэтэй цахилгаан хэргэлдэг энэ нь нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийг иргэдийн цахилгааний төлбөр дээр нэмж оруулж байгаа нь цахилгааны үнийг нэмж байгааг өөрчилж өөр эх үүсвэрээс нийтийн эзэмшлийн зам талбайг гэрэлтүүлдэг болгох саналыг уламжилж шийдвэрлүүлэх.
- 1.2 14 дүгээр баг нь гэр хороолол байдаг халаалт дулаанаа мод, нүүрс түлж шийдэж байгаа асуудлыг аймаг орон нутагт асуудал оруулж шахмал түлшний үйлдвэр бариулж иргэдийг шахмал түлшээр хангах асуулыг уламжилж шийдвэрлүүлэх.
- 1.3 Гэрийнхээ халаалт дулааны асуудлыг цахилгаанаар шийдсэн иргэдийн цахилгааныг шөнийн тарифтай болгох саналыг уламжилж шийдвэрлүүлэх.
- 1.4 Мөрөн сумын агаарын бохирдол ихсэж байгаа асуудлыг аймгийн ИТХ-д уламжилж санал оруулж Монгол улсын засгийн газарт уламжилж утааг бууруулах чиглэлээр хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх.
- 1.5 Ажилгүйдэл ядуурлыг бууруулах, ажлын байр шинээр бий болгох, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг дэмжих чиглэлээр багийн иргэдийн санал хүсэлтийг уламжлах.
- 1.6 Гэр бүл салалт их байгаа нь иргэдийн ажиллах ажлын байр аймгийн хэмжээнд байхгүй гадаадад ажиллах, өөр орон нутагч ажиллах байдлаас болж нэмэгдэн хүүхэд өнчрөх гэр бүлийн халуун дулаан орчин байхгүй болж байгаа асуудлыг аймгийн ИХТ-д уламжилж ажлын байр шинээр бий орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ ажлын байр бий болгох асуудлыг уламжлан шаардах.
- 1.7 Мөрөн суманд үерийн далан ус зайлуулах суваг шуудуу барих асуудлыг уламжилж шат дараалалтай шийдвэрлүүлэх.

ХОЁР: БАГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД БОЛОВСРОЛЫН АСУУДЛЫГ  
ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.1 Багийн иргэдийн эмнэлгийн үзлэг оношилгоонд бүрэн идэвхитэй хамруулж эрт оношлох эмчлэх асуудлыг багийн эрүүл мэндийн төвд шаардаж гарафикын дагуу үзлэг оношилгоог хийлгэх.
- 2.2 Багийн нутаг дэвсгэрт хүүхэд залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх спорт тоглоомын талбайтай болгох асуудлыг ИТХ-д уламжилж шийдвэрлүүлэх.
- 2.3 Багийн иргэдэд аймаг орон нутгийн төр захиргаанаас явуулж байгаа бодлого үйл ажиллагааг сурталчилж мэдээлэх
- 2.4 Иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ёс зан заншилд сургах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.

*(Handwritten signature)*

*(Handwritten signature)*


0000002

ГУРАВ: ИЛ ТОД ШУДРАГА БАЙДЛЫГ ТОГТООХ ЧИГЛЭЛЭЭР.

3.1 Төрийн жинхэнэ алба хаагчдыг нам харгалзан халдаг сольдог асуудлыг таслан зогсоох талаар ИХТ-д санал оруулж тогвортой ажиллах чиглэлээр ИТХ-н тогтоол гаргуулахаар санал тавих. Энэ чиглэлээр нам эвсэл олон нийтийн байгууллагатай хамран ажиллах.

3.2 Улс төрийн шийдвэр гаргахад аливаа нэг нам эвслийн эрх ашгийг биш хөвсгөл аймгийн нийт иргэдийн эрх ашгийг нэгдүгээр тавьж тэдний санал хүсэлтийг тусгах.

3.3 Аливаа томилгоо, төндрийг олон нийтэд ил тод нээлттэй явуулахыг шаардан ямар нэгэн хууль бус зүйл гаргавал тухай бүр нь хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.

 ..... /А.Энхбаяр/  
Утас:99180872



